



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-32
1.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх	11-12
2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	12-22
3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	23-26
4.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	26-32

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 26-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 72 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, С.Амарсайхан, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга, Б.Бейсен, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Т.Доржханд, С.Замира, Г.Лувсанжамц, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, Н.Учрал, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Ч.Анар, Б.Батцэцэг, Ж.Баярмаа, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Л.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Л.Гантөмөр, С.Лүндэг, З.Мэндсайхан, С.Одонтуяа;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, О.Амгаланбаатар, Ж.Батсуурь, Ш.Бямбасүрэн, Б.Жавхлан, Д.Жаргалсайхан, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Н.Алтаншагай-10 минут, М.Бадамсүрэн-11 минут, Д.Батлут-40 минут, П.Батчимэг-32 минут, Э.Батшугар-05 минут, Г.Ганбаатар-45 минут, С.Ганбаатар-55 минут, Д.Ганбат-09 минут, Б.Жаргалан-14 минут, Л.Мөнхбаатар-20 минут, Ц.Мөнхтуяа-26 минут, Э.Одбаяр-40 минут, Б.Тулга-04 минут, Б.Түвшин-08 минут, А.Ундраа-21 минут, Ч.Ундрэм-06 минут, Г.Хосбаяр-01 минут, Ж.Энхбаяр-49 минут.

Өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг танилцуулах

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа Монгол Улсын Засгийн газраас 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Төсвийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 16 гишүүнээс 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

Нэг.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур,

Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх асуудлыг Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа танилцуулав.

Х.Булгантуяа: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	25
Бүгд:	77

67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын зөвлөх Т.Алтангэрэл, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга Т.Энхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Х.Булгантуяа: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтад доор дурдсан агуулгатай 17.3 дахь хэсэг нэмэх:

4/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:

“17.3.Тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг хангасан эсэхийг энэ хуулийн 17.2.4-т заасан үнэлгээнд нэмж тусгана:

17.3.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх;

17.3.2.ялгаварлан гадуурхаагүй байх;

17.3.3.хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Х.Булгантуяа, О.Номинчимэг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	47
Татгалзсан:	39
Бүгд:	86

54.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, П.Батчимэг, Д.Ганбат, П.Ганзориг, М.Ганхүлэг, Б.Найдалаа, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Б.Хэрлэн, С.Цэнгүүн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 86 гишүүнээс 58 гишүүн дэмжиж, 67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.6-д заасан аргачлал хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 25
Бүгд: 86
70.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 18.3 дахь хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаач” гэснийг “хууль зүй, төсвийн судалгааны чиглэлийн хүн, хуулийн этгээд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 28
Бүгд: 86
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 28.3.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.3.6.асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа явуулах журам, бүрэн эрх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 25
Бүгд: 86
70.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 51.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 29
Бүгд: 86
66.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.6.Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг үндэсний эрх зүйн тогтолцооны онцлог, хөгжлийн чиг хандлагыг харгалзан оновчтой хувилбарыг, үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан хийх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
 Татгалзсан: 26
 Бүгд: 86
 69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

Х.Булгантуяа: 1.Төслийн 2 дугаар зүйлийн “38 дугаар зүйлийн” гэсний өмнө “34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэсний өмнө “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж” гэж,” гэж, 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн” гэсний өмнө “33.5 дахь хэсгийн “33.3.3-т” гэснийг “33.3.5-д” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийн “40.1.3-т” гэснийг “40.1.3, 40.1.4-т” гэж, 38.9 дэх хэсгийн “12.2.23, 12.2.24-т” гэснийг “12.4-т” гэж,” гэж, “40 дүгээр зүйлийн” гэсний өмнө “39.4 дэх хэсгийн “39.3-т” гэснийг “39.3, 39.4-т” гэж,” гэж, 5 дугаар зүйлийн “12.2.1,” гэсний дараа “12.2.17” гэж, мөн төсөлд “**6 дугаар зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн зүйл нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.1 дэх заалтын “хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахад” гэснийг “хэрэгжүүлэхэд” гэж, 27¹.1.2 дахь заалтын “зорилтод” гэснийг “зорилт, үйлчлэх хүрээнд” гэж, 2 дугаар зүйлийн “жагсаасан” гэснийг “байрлуулсан” гэж өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дугаар дахь заалт буюу 27¹.1.5 дахь заалтын “үндсэн” гэснийг, 2 дугаар зүйлийн “39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийн “39.3” гэсний дараа “, 39.4” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “энэ хуулийн 41.3” гэсний дараа “, 41.4” гэж,” гэснийг, 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэснийг “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж хавсаргана” гэж,” гэснийг, “мөн зүйлийн 41.4, 41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10 дахь хэсгийн дугаарыг “41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10, 41.11” гэж, 41.5 дахь хэсгийн “41.4-д” гэснийг “41.5-д” гэж, 41.7 дахь хэсгийн “41.5-д” гэснийг “41.6-д” гэж,” гэснийг, мөн зүйлийн “эх бичвэрийн” гэсний өмнөх “англи хэл дээрх” гэснийг, 5 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг, ” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
 Татгалзсан: 31
 Бүгд: 88
 64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн Я.Цэлмэн, мөн Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга П.Оростогоо, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Д.Сандаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Х.Булгантуяа: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалтын 9 дэх хэсгийн “танилцуулж, төрийн нууцад хамаарахаас бусад хэсгийг” гэснийг “танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	37
Бүгд:	89

58.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	31
Бүгд:	89

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24/36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	32
Бүгд:	89

64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 2 дахь хэсгийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг хасаж, мөн заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогчид хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хавтаст хэргийн материал танилцуулах хугацаа 7 хүртэл хоногт, бусад хэргийн материалтай ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах боломж, нөхцөлөөр хангана. Хавтаст хэргийн материал танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэл хоног байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан тус хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн:	51
Татгалзсан:	38
Бүгд:	89

57.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Ч.Номин нар үг хэлэв.

Х.Булгантуяа: Байнгын хорооны саналаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 32

Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 11 минут үргэлжилж, 126 гишүүнээс 91 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

**2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
17 цаг 06 минут**

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж байна.

Улсын Их Хурлын 126 гишүүнээс 72 гишүүн 57.1 хувийн ирцтэйгээр өнөөдрийн чуулганы хуралдааныг эхэлж байна.

2025 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 6 асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хоёрдугаарт, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвд, Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Үдээс хойш Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тавдугаар асуудал.

Зургаад, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагч Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

Нэгд, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон уг хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд.

Хоёрт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа нарын 16 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Эхний асуудалдаа оръё. Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх, хэлэлцэх асуудал.

Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан тул Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон уг хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Эдгээр хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яалтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Эхлээд гишүүдийн ирцийн 1 санал хураалт явуулчихъя. Тэгье. Санал хураалтад гишүүд бэлтгэе.

Эхлээд бүртгэлийн санал хураалт 1 явуулъя. Гишүүд хуруугаа уншуулаад бэлэн байдлаа хангачихсан тээ санал хураалтад бэлтгэхэд? Бүртгэлийн санал хураалт.

Дээрх хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүдийн 67.5 хувь нь дэмжлээ.

Ийнхүү хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.13 цаг

Хоёрдугаар асуудалдаа оръё. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар нарын 9 гишүүнээс 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Пүрэвжавын Сайнзориг нар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх танилцуулгатай холбогдуулан ажлын хэсгээс асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасныг баримтлан гүйцээн боловсруулахад чиглэл өгсний дагуу ажлын хэсэг хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй 5 санал, найруулгын 3 санал, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг баримтлан анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч гүйцээн боловсруулалт чиглэл авсан 1 зарчмын зөрүүтэй саналыг боловсруулж Байнгын хорооны хуралдаанаар санал хураалгасан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Наранчулууны Отгончимэг Улсын Их Хурлын даргын зөвлөх, Тайванхүүгийн Алтангэрэл Улсын Их Хурлын даргын зөвлөх, Чулуунбаатарын Дондогмаа Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга, Ганхуягийн Агар-Эрдэнэ Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх, Сандагийн Тунгалагтамир Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга. Тунгалагтамир ирсэн юм уу? Ажлын хэсгийн гишүүд нь хаагуур байна? Төгсийн Энхбаяр Монголын Өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн өмгөөлөгчийн зөвлөлийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. 4 гишүүний нэр ирсэн байна.

Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Би чинь хамгийн түрүүнд болчихлоо. Ажлын хэсгийн дарга Номинчимэг гишүүнээс энийг хуулийн хулгай гэж хэлэх нь ч хаашаа юм. Ажлын хэсгийн хүрээнд уг нь бол өнгөрсөн хэлэлцүүлгийн үед Байнгын хорооны дэмжээгүй саналыг босгох буюу яг энэ жендерийн мэдрэмжтэй хууль санаачлагчид өргөн барьсан төсөл дээр яг энэ жендерийн мэдрэмжтэй жендерийн үнэлгээ хийх гэсэн ийм саналыг оруулж ирсэн. Жендерийн эрх гэдэг бол өөрөө хүний эрх мөн. Үүнийг уг нь босгох боломж бол яг өнгөрсөн чуулганаар байсан. Найруулгаар үүнийг засъя гэж ажлын хэсэг рүүгээ, Байнгын хороо руугаа эргүүлэн

татсан. Одоо ямар ч санал өгөх, засах боломжгүйгээр жендерийн үнэлгээний хэсгийг бүүр хасаад оруулаад ирчихсэн байна. Одоо ямар ч арга алга. Яагаад энийг энэ жендерийн гэдэг үгийг ингэж их ад үзээд байгаа юм бэ? Би ердөөсөө ойлгохгүй байна. Олон улсын парламентын хуралд бас та оролцож байсан шиг л санаж байна. Олон улсын парламентын төлөөлөл өчигдөр, уржигдар бас манай Монгол Улсад хурал зохион байгуулсан. Олон улсын парламентын холбооноос бас манай Улсын Их Хурлын өөрийн жендерийн үнэлгээг бас хийсэн. Жендерийн энэ үнэлгээ, оролцоогоор бүхий л дэлхийн улс орнуудад хүртэл энэ зөвлөмж, зөвлөгөөг өгдөг, үнэлдэг.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд хүртэл энэ жендерийн эрх тэгш байдлыг хангах гэсэн асуудлууд байгаад байдаг. Жендерийн үндэсний хороо гэж манайд бас олон жил үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага 2018 оноос хойш энэ хууль тогтоомжид жендерийн нөлөөллийн үнэлгээ хийх талаар ажил хийж гүйцэтгэсэн. Энэ бүхнийг үгүйсгээд ямар ч өөрчлөх боломжгүйгээр хуулийг оруулаад ирэх юм. Одоо яах вэ? Үнэхээр бухимдаж байна. Засгийн газрын түвшинд ч гэсэн энэ Жендерийн тухай хууль ухралт, том ухралт 2-хон эмэгтэй сайдтай. 183 улс орноос бараг 150, 60 руугаа орсон. Засгийн газрын бүтэц хийгдсэн байна лээ. Бүх яамдын бүтэц цомхотгосон. Газар, хэлтсийн дарга нараа сонгохдоо Улсын Их Хурлын гишүүд, сайд нар минь ээ Жендерийн тухай хуулиа хараарай. Хууль тогтоогчид өөрсдөө хуулиа мөрддөггүй байгаа асуудлыг яах вэ нээрээ? Энэ жендерийн гэсэн үгийг яагаад хасчхав, оруулсангүй? Манай Баасанжаргал гишүүн яг наана чинь нэг газрын зураг барьж байна. Наад дээр чинь байгаа биз дээ үнэлгээ бүх улс орнуудын парламент дээр нь энэ үнэлгээг нь хийсэн? Жендерийн гэсэн энэ үнэлгээг оруулах боломжтой юу, боломжгүй юу одоо?

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн дарга Номинчимэг хариулъя.

О.Номинчимэг: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энийг хуулийн хулгай ч гэдэг юм уу, байхгүй болгочихлоо гэдэг зүйл байхгүй. Бид нар Хууль тогтоомжийн хууль суурь хууль. Энийг хууль зүйн хувьд дараа нь хэрэгжүүлэхэд юун дээр анхаарах вэ, хууль зүйн хэм хэмжээ, концепцын дэс дараа, эрэмбэ юу байх вэ гэдэг дээр ажлын хэсэг нэлээн анхаарч ажилласан. Техникийн хувьд бол энэ жендерийн мэдрэмжтэй гэдэг үгийг угаасаа хасахаар ажлын хэсгээс санал болгосон байсан. Энэ яг 17.3 гэсэн хэсэгтэй холбоотой л баахан ийм зүйл, заалтууд хоорондоо зөрчилтэй байж магадгүй зүйл, заалтууд өмнөх чуулган дээр босоод чиглэл аваад дэмжигдээд ингээд явсан. Түүний хүрээнд ажлын хэсгээс энэ 17.3-ыг бүгдийг нь шинэчилж ажлын хэсгийн зүгээс саналуудаа бас тусгаад энэ зүйл, заалтыг оруулж ирж байгаа юм.

Жендерийн мэдрэмж гэдэг бол, жендерийн эрх тэгш байдал бол ойлгомжтой. Бид конвенцтой нэгдээд орчихсон. Үндсэн хуулиараа ч гэсэн үүнийг баримталдаг. Энийг ч бид нар хэрэгжүүлэхийн төлөө хамтдаа явж байгаа. Жендерийн эрх тэгш байдал буюу хүйсээр ялгаварлан гадуурхах гэдэг асуудал бол өөрөө энэ 17.3.2-т заасан ялгаварлан гадуурхахгүй байх гэдэг энэ зүйл заалтдаа орчихдог юм. Олон улсын гэрээ, конвенцод хүний эрхийг хязгаарлахдаа ерөөсөө 4 шалгуур байна. Хуульд үндэслэсэн байна, зайлшгүй шаардлагатай байна, пропорционал/proportional/ буюу арга нь тохирсон байна гээд энэ шалгуурууд

байдаг юм. Энэ дотор чинь яг энэ жендерийн юм чинь өөрөө дотроо ороод явчихдаг учраас тусад нь энэ нөгөө томьёолол Жендерийн үндэсний хорооноос жендерийн мэдрэмжтэй байх гэдэг томьёолол орж ирж байгаа байхгүй юу. Энэ мэдрэмжтэй байх гэдэг чинь өөрөө концепцын хүрээний асуудал. Жендерийн мэдрэмж гэдэг нь нөгөө хүйсээр эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлал болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл, эрмэлзэл, мэдлэг чадвар тодорхойлсон ойлголтыг хэлнэ гэж байгаа юм. Энэ өөрөө хэм хэмжээний шалгуур үзүүлэлт гэхээсээ илүү яг хийж байгаа үйл ажиллагаа дээр, гарч байгаа үл үр нөлөөн дээр ассессмент/assessment/ буюу үнэлгээг хийдэг.

Энийг цөмөөрөө тэгвэл яаж илүү бас тодотгох ёстой вэ гээд бас харсан. Энийг бид нар Ай Пи Юу-гийн тэр жендерийн мэдрэмж жендерийн төслийнхөнтэй ч ярьсан. Би ч гэсэн энэ чиглэлээр анхаарч ажилладаг хүн. Энэ хуулийг дагаад Засгийн газарт энэ хуулийн үнэлгээ, аргачлалуудыг шинэчлэх ийм чиглэл өгч байгаа. Энэ аргачлал дунд хүний эрхийн үнэлгээ хийдэг энэ аргачлал байгаа Хууль зүйн яамнаас боловсруулсан. Бид энэ аргачлалаа угаасаа шинэчлэх бас цаг болсон. Энэ аргачлалын хүрээнд хүний эрхийн аргачлал энэ нөхцөл байдлын үнэлгээ нь ямар байна гэдэг дээр заавал энэ жендерийн мэдрэмж байна уу, жендерийн үнэлгээ маань байна уу гэдгийг оруулж өгөх ёстой юм. Салангид гэхээсээ энэ өөрөө цогц байж яг энэ төрийн захиргааны байгууллагууддаа энэ маань цогцоороо явдаг бас байх ёстой гэсэн.

Х.Булгантуяа: Ариунзаяа гишүүн нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: Миний хувьд миний санал өгөх эрхийг хулгайлсан л гэж би бол үзэж байгаа. Яагаад гэвэл би үнэхээрийн санал өгөөд энэ жендерийн гэдэг үгийг эргүүлэн оруулах боломжгүй болсон байна. Одоо яая гэх вэ. Жендерийн гэдэг үгийг, Жендерийн тухай хуулийг, Жендерийн үндэсний хорооны ажлыг үгүйсгэж байгаа нь бол үнэхээрийн санаа зовниулж байна. Тэгэхээр энэ жендерийн гэдэг энэ асуудал байх ёсгүй юм бол жендерийн үндэс, жендерийн асуудал зүгээр л хүний эрхийн асуудал юм бол Жендерийн үндэсний хороог татан буулгаад Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хуулийг хүчингүй болгоод тэр хүний эрхийн хороо, Хүний эрхийн Комисс Хүний эрхийн хуульдаа шингээнэ биз ээ.

Засгийн газар 2-хон эмэгтэй сайдтай. Шийдвэр гаргаж байгаа хүмүүс чинь дандаа эрэгтэй хүмүүс байгаад байна шүү дээ. Жендерийн хуулиа ч мөрдөхгүй. Улс төрийн намын тухай хуулиа хойшлуулах гэж оролдсон, улс төрийн намууд Удирдах зөвлөл Бага хуралдаа 40 хувийг эмэгтэйчүүдээ бүрдүүлэх ёстой шүү дээ. Гүйцэтгэх засаглал нь өөрөө хуулиа мөрдөхгүй, хууль тогтоох байгууллага нь өөрөө.../минут дуусав./

Х.Булгантуяа: Номинчимэг гишүүн нэмж хариулъя.

О.Номинчимэг: Бид нар өмнөх анхны хэлэлцүүлэг дээр чуулганаар энэ 17.3 маань Сайнзориг гишүүний бүхлээр нь хасах гэдэг санал дэмжигдчихсэн юм. Тэгэхээр яг энэ хууль зүйн техникийн хувьд энэ дэмжигдсэн санал байгаа учраас энийгээ яаж буцааж орох вэ гээд бүхлээр нь харахаас өөр аргагүй. Тэгэхээр тусад нь юу гэдэг юм жендерийн мэдрэмжийг хасна, хасахгүй гэсэн саналын томьёолол

орж ирэх боломжгүй болсон. Энэ сая Байнгын хороон дээр ч гэсэн өчигдөр бид нар бас нэлээн энэ дээр юм болж байгаад яг хууль зүйн техникийн хувьд энэ нь зөв юм байна гэдэг шийдэлд хүрээд ингэж байгаа. Тэгэхээр таны бас эрхийг гэхээсээ илүү яг ийм хууль зүйн техникийн юундаа дэгдээ баригдаад иймэрхүү саналын томъёолол орж ирж байгаа гэдгийг хэлмээр байна. Ер нь таны хэлж байгааг бас ойлгож байгаа. Бид нар Жендерийн эрх тэгш байдлын хуулийн хэрэгжилтийн намар угаасаа хугацаагаараа Хууль зүйн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо хамтарч хэлэлцэнэ. Энэ дээр бид нар бас Засгийн газарт хүчтэй чиглэл өгөхдөө хуулийн хэрэгжилтээ хангуулах тал дээр бас хамтран ажиллахад бол бэлэн байгаа гэдгийг хэлмээр байна.

Х.Булгантуяа: Ариунзаяа гишүүн 1 минут нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: Харин тийм ажлын хэсгийн хасъя гэсэн саналыг Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй байхгүй юу. Энэ дэмжээгүй саналыг нь дэмжиж уг нь хэвээр нь үлдээх боломж байсан юм. Одоо ийм боломжгүй болчихсон байна гэдгийг л хэлээд байгаа юм. Засгийн газар одоо яамнууд бүтцээ шинээр баталсан байгаа. Жендерийн хуулиа мөрдөөрэй. Хууль зөрчсөн сайд нарт хариуцлага тооцох талаар албан тоот явуулах эрх нь бас энэ Жендерийн тухай хуулиар олгогдож байгаа шүү. Одоогийн байдлаар энэ Жендерийн тухай хууль байгаа шүү. Байгаа. Үүнийгээ та хэд маань бас мөрдөөрэй гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ариунзаяа гишүүн санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл.

Б.Мөнхсоёл: Бүгдийнх нь өглөөний амрыг айлтгая. Дэд дарга хэлээд байна чимээгээ аядахгүй бол бас сонсогдохгүй байхаар байна. 2 тодорхой асуулт асуучихъя гэж бодож байна. Номинчимэг гишүүн дээр 6.27 дугаар зүйлийн 27.1 дээр захиргааны хэм хэмжээ батлах, акт олгох энэ эрх олгогдсон бол тухайн хуулийн төслүүдэд тавигдах шаардлага гэсэн ийм шинэ зүйл нэмэр орж ирснийг дэмжиж байгаа юм.

Харин одоог хүртэл хэрэгжиж байгаа журмууд байгаа шүү дээ? Нэлээн эрх олгогдчихсон байсан олон журмууд гарчихсан. Энэ журмуудыг энэ шинэ хуулийнхаа энэ 27.1-д тавигдаж байгаа шаардлагад нийцүүлэх ажил хийгдэх үү? Энэ шилжилтийн үеийг хэнээр, хэрхэн яаж, хэзээ хийлгэх вэ? Монгол Ардын нам өөрөө олон хуулиудад, журмуудад шинжилгээ хийгээд 800 гаруй заалт хүний эрхийг зөрчсөн байна гэдэг ийм судалгааны үр дүн гаргачихсан байгаа. Энэ дээр өөрийн чинь бодол юу байна? Энийг яаж нийцүүлэх вэ?

Хоёрдугаарт нь Нээлттэй нийгэм форумаас 3 ч судалгаа ийм бодлогын ийм шийдлийн ийм пэпер/рареп/-үүд гарсан байгаа. Энэ дээр болохоор гол бас хөндөж байгаа асуудал нь хуулийн төсөл барихдаа, судалгаа хийхдээ хуучин хийгдчихсэн байсан судалгааны үр дүнгүүдийг шаблон маягаар ерөнхийд нь нэг хашилт дотор халтуур маягаар ашиглаад байна. Тусгай яг бэлтгэгдсэн энэ судлаачдаараа, хөндлөнгийн хараат бус судлаачдаараа энэ судалгааныхаа ажлуудыг хийлгэхгүй юм уу? Энэ дээр яаж хариуцлага илүү чанартай ажлыг хийлгэх тал дээр энэ хуулийн төсөл маань хэрхэн асуудлыг шийдэж байгаа вэ? Энэ дээр би бас хувь гишүүний хувьд санаа зовж явдаг хүн байгаа юм. Энэ 2 тодорхой асуултыг асуучихъя.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн дарга Номинчимэг хариулъя.

О.Номинчимэг: Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Эхний асуултад яг энэ захиргааны хэмжээний актыг бид нар Улсын Их Хурлаас ямар хүрээ, хязгаараар өгөх ёстой, энэ шалгуур тавихгүй бол бас хэм хэмжээний актуудын дагаж мөрдөх энэ хууль зүйн систем маань жоохон гажуудалд орчихсон байна гэсэн дүгнэлт гарч байгаа. Тэгэхээр энэтэй холбоотойгоор энэ шаардлагыг хуульдаа оруулж өгсөнтэй холбоотойгоор энэ хуулийг дагаж Улсын Их Хурлын тогтоол гарч байгаа. Үүгээрээ Улсын Их Хурлаас Засгийн газарт чиглэл өгөөд яг энэ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ялангуяа Хууль зүйн яам дээр хэм хэмжээний дагаж мөрдөх актын сан байдаг. Энэ дээрээ яг үнэлгээ, дүгнэлт бүгдийг нь хийгээд хүчингүй болгох, засах залруулах юмаа хий гэдэг чиглэл өгч байгаа. Энийг хугацаатай 2026 оны 5 сарын гэхэд энэ ажлыг хийж гүйцэтгэх гэсэн ийм чиглэлтэйгээр тогтоол бас дагаж орж ирж байгаа.

Хоёрдугаарт, таны хэлж байгаа яг хөндлөнгийн судлаач, шинжээчдийн асуудал бас яг хөндөгдөж орж ирсэн. Анх хууль боловсруулагчдын зүгээс ч гэсэн энэ асуудалд энэ шүүмжийг аваад 2 асуудал дээр бол яг энэ хөндлөнгийн судлаач, шинжээчдээр хийлгэж байя гэдэг юм оруулж ирж байгаа.

Нэгдүгээрт, хууль тогтоомжийн үр нөлөөний үнэлгээ гэдэг зүйлийг заавал хийж хууль боловсруулагч маань, хууль санаачлагч маань оруулдаг. Энийг бол заавал хөндлөнгийн судлаач, судалгааны байгууллагаар хийдэг бол гэсэн энэ заалтыг бол 19.3 дээр билүү дээ орсон байгаа. Мөн Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө хууль санаачлахаар бол энэ зардлын тооцоолол гэх мэт энэ баримт бичгээ нэг бол Улсын Их Хурлын Тамгын газраар, нэг бол яг энэ хууль зүй, төсвийн чиглэлээр ажилладаг хүн, хуулийн этгээд, судлаачдаар хийлгээ, хийлгэж болно гэсэн ийм зүйл заалтыг оруулж ирж, энэ судалгааны үр нөлөөний үнэлгээний өөрөө хуулиа боловсруулж үзэл баримтлалаа боловсруулчихаад энэ нь ямар байх вэ гэдэг дээр өөрөө субъектив байдлаар хийх биш хөндлөнгөөс энийг нь хийдэг болъё гэсэн концепцыг бол энэ хуульд тусгаад орж ирсэн байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Мөнхсоёл гишүүн нэмж тодруулъя. Мөнхсоёл гишүүний микрофоныг өгье 1 минут.

Б.Мөнхсоёл: Номинчимэг гишүүнд баярлалаа. Дахиад зүгээр үг хэлчихье гэж бодож байна. Жишээлбэл D-parliament дээр D-parliament.mn дээр хуулийн төслүүд тавигдаж байгаа шүү дээ. Тухайн хууль, тогтоолын тогтоомжийн төсөл дээр эрх бүхий байгууллага, албан тушаалтан, шинжээчдийн хийсэн эрх зүйн дүгнэлтийг хамтад нь нийтлэхгүй байгаа байхгүй юу. Нийтлэхгүй байгаагаас хууль тогтоомжийн төслийн агуулга, хэлбэр, бүрдэлд тавьсан хяналтын талаар олон нийт мэдэх боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөл дангаараа тавигдаад олон нийт бүрэн гүйцэд мэдээлэл авч чадахгүй байна. Тийм учраас эсвэл эсэргүүцэх, эсвэл бурууг дэмжих ийм үзэгдэл газар авах гээд байна. Энэ дээр бас анхаарч оруулсан байх гэж найдаж байна Номинчимэг гишүүнийг. Баярлалаа. Ажлын хэсгийг.

Х.Булгантуяа: Номинчимэг гишүүн нэмж хариулъя.

О.Номинчимэг: Энэ дээр илүү энэ хууль маань ямар үзэл баримтлалтай, ямар судалгаан дээр үндэслэлийн гэдэг ил тод байдлыг хангахын тулд бас нэмэлт энэ зохицуулалтууд орж ирсэн. Энэ хуулийн 45.3 дээр ер нь энэ хууль маань лигл инфо/legalinfo/гээд бид нарын эрх зүйн хууль тогтоомжийн сан байдаг. Энэ сан дээрээ батлагдсан хуулийнхаа эхийг хууль тогтоомжид оруулсан тэр нэмэлт, өөрчлөлт, үзэл баримтлал, яг хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ гээд тайлан хийдэг. Энэ тайлангаа заавал хавсаргадаг. Энэ маань бидний хэлж заншсанаар лигл инфо/legalinfo/ дээр бол олон нийтэд нээлттэй, ил тод байх ийм нөхцөл нь бас бүрдэж байгаа гэдгийг энд хэлмээр байна.

Х.Булгантуяа: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 7 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болохоор байгаа дэгтэй холбоотойгоор.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн санал хурааж дэмжсэн санал.

1.Төслийн дүгээр зүйлийн 4 дэх заалтад доор дурдсан агуулгатай 17.3 дахь хэсэг нэмэх:

4/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:

“17.3.Тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг хангасан эсэхийг энэ хуулийн 17.2.4-т заасан үнэлгээнд нэмж тусгана:

17.3.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх;

17.3.2.ялгаварлан гадуурхаагүй байх;

17.3.3.хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.”. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.

Энэ саналтай холбогдуулан Тэмүүжин гишүүн. Гишүүд ээ хуруугаа уншуулаад санал хураалтад бэлдээрэй.

Х.Тэмүүжин: Энэ санал хураалттай холбоотойгоор нэг үг байгаа. Протоколд тэмдэглүүлэхийг хүсэж байгаа. Нийгмийн хэм хэмжээ гэдэг энэ ойлголтыг бид яг ямар ойлголт вэ гэдгээрээ жоохон Хууль зүйн байнгын хороон дээр маргасан.

Үндсэн хууль дээр хэрэглэгдсэн ойлголт учраас нэр томьёог нь ашиглаж байгаа гэсэн утгатай. Энэ өөрөө уул нь бол паблик ордер/public order/ буюу нийтийн хэм хэмжээний тухай ойлголт байгаа. Нийгмийн гэдэг үгийг ашиглачихаар хэмжигдэхэд төвөгтэй субьектив болдог. Бид бол Улсын Их Хурлын стратегиа баталсан. Бидний стратегийн хамгийн гол зорилго бол хүний эрхэд суурилсан хүн төвтэй хуулийн бодлогыг хэрэгжүүлнэ. Хууль тогтоомжийг энэ чиглэл рүү боловсруулж батална гэдэг ийм зорилт тавьсан. Яагаад энэ нийгмийн, эсхүл нийтийн гэдэг 2 үгийн ялгаа гараад байгаа юм бэ гэхээр ер нь нийгмийн гэхээр субьектив төдийгүй хүнээсээ тасарчхаж байгаа юм. Нийтийн гэх юм илүү олон хүнд хамаатай олон хүний дунд тогтсон хэвшсэн хэм хэмжээний тухай ярьж байгаа юм.

Тийм учраас өнөөдөр энэ Хууль тогтоомжийн хууль дээр нийгмийн хэв журам гэдэг үг хэрэглэгдэж байгаа боловч цаад агуулгаараа нийтийн хэв журам буюу хүмүүсийн дунд тогтсон хэв журамд гэдэг энэ агуулгаар нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой хууль орж ирж байгаа бол бусад олон хүний аюулгүй байдал, тэдний нийтлэг ашиг сонирхол, хэм хэмжээг эрхэмлэх, хамгаалах зорилготой хязгаарлалт орж ирж байгаа шүү гэдэг агуулга хэрэглэж байгаа шүү.

Тэгэхгүй бол Хууль тогтоомжийг боловсруулан оруулж ирэхдээ хэтэрхий хийсвэр, субьектив хүндээ наалддаггүй, хэмжигддэггүй тийм агуулга орж ирж, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах болчих вий гэдэг болгоомжлол байгаа учраас дахиад протоколд тэмдэглэж бичүүлж байгаа юм шүү.

Х.Булгантуяа: Үүнтэй холбоотой би бас үг хэлье гэж бодож байна. Энэ 17.3.2 ялгаварлан гадуурхаагүй байх гээд энэ өмнө нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ялгаварлан гадуурхалттай холбоотой эрх зүйн орчныг сайжруулж ялгаварлан гадуурхалтын эсрэг хуультай больё гэхэд Хууль зүй, дотоод хэргийн яам ийм хууль тусгайлан байх ёсгүй. Харин эсрэгээрээ бусад хуулиудад энийг шийтгэж өгөх ёстой. Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль гэдэг юм уу ийм байдлаар хийх ёстой гэсэн байдлаар байгаа мөртөө энэ Хууль тогтоомжийн тухай хууль дээр бүүр тусгайлан зүйл, заалт болоод орчихсон. Хэрвээ энэ ялгаварлан гадуурхаагүй байх гэж байгаа бол одоо ялгаварлан гадуурхалт зөвхөн жендер, хүний эрхийн асуудал биш бүүр нарийн ялгаварлан гадуурхалт болоод байна шүү дээ. Тэгэхээр үүнийг бүүр тэгвэл нарийвчилж бүүр хуульчилж өгөх ёстой. Тэгэхээр үүн дээр бас манай хуульчид бас анхаараарай гэж хэлмээр байна.

Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ Тэмүүжин гишүүнтэй бол санал нэг байгаа нийгмийн хэв журам гэдэг үгийг. Манай Монгол улс чинь энэ олон улсын НҮБ-ын Улс төрийн болон нийгмийн хүний эрхийн конвенцод бүр 1974 онд гарын үсгээ зураад авчихсан. 1992 онд Үндсэн хуулиа хийхдээ энэ паблик ордер/public order/ гэдэг үгийг тухайн үедээ бол нийгмийн хэв журам л гээд л орчуулчихсан л юм байна лээ. Бид нарын орсон олон улсын гэрээ, конвенцоор бол яг энэ бол паблик ордер/public order/ буюу нийтийн хэв журам, нийтийн аюулгүй байдал гэдэг утгаар ордог. Энэ яах вэ энэ ийм ойлголт зөрүүтэй гэхээсээ илүү угаасаа бид нар паблик/public/ гэдэг үгийг нийгмийн л гээд л орчуулаад сурчихсан юм байна лээ л дээ.

Тэгэхээр энд нийгмийн гэхээсээ илүү өөр ойлголт гэхээсээ илүү жишээ нь паблик хэлф/public health/ буюу нийгмийн эрүүл мэнд гэж байна. КОВИД гарлаа, янз бүрийн халдварт өвчин гарлаа, улаан бурхан гарлаа, энэний төлөө ямар нэгэн хязгаарлалт бол хийх бас үндэслэл байж болно гэдэг юм байгаа. паблик хэлф/public health/ гэдгийг бид нар нийтийн эрүүл мэнд биш нийгмийн эрүүл мэнд л гэж ярьдаг. Угаасаа орчуулаад сурчихсан юм байгаа. Үндсэн хууль дээрээ бид нар ялт ч үгүй ийм нэр томъёо байгаа учраас үүгээр нь оруулчихсан. Гэхдээ утгын хувьд бол яг бусад нийтээр хамарсан хүнийхээ эрх ашгийг хамгаалахын тулд гэдэг утгаар ойлгогдож байгаа гэдгийг бас нэмж хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд санал хураалтад бэлдсэн байх. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүдийн 54.7 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Баасанжаргал гишүүн, Хэрлэн гишүүн, Ганхүрэл гишүүн. Өө ямар олон хүмүүс болчхов. Найдалаа гишүүн, Ганзориг гишүүн, Уянгахишиг гишүүн, хойгуур Цэнгүүн гишүүн, Очирбат гишүүн, Пунсалмаа гишүүн дэмжсэнд. Батчимэг гишүүн, Ганбат гишүүн. Эдгээр гишүүдийг дэмжсэнд тэмдэглэлд тусгаарай. Дараачийн асуудал.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу санал хурааж дэмжсэн санал.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.6-д заасан аргачлал хамаарахгүй.”. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Гишүүдийн 70.9 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 18.3 дахь хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаач” гэснийг “хууль зүй, төсвийн судалгааны чиглэлийн хүн, хуулийн этгээд” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Гишүүдийн 67.4 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 28.3.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.3.6.асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа явуулах журам, бүрэн эрх;”. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

70.9 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 51.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтыг түр цуцалъя. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ төсөл дээр орж ирсэн 51.5 буюу хууль боловсруулагч заавал хуулийн төсөл өргөн барихдаа энэ үнэлгээ, хууль тогтоомжийн үр дүнгийн үнэлгээ хийдэг болно гэсэн заалтыг хасаж байгаа. Эндээ холбоотойгоор протоколд тэмдэглүүлэх юм байгаа юм. Бид нар энэ хуулиа хараад одоо Хууль тогтоомжийн хуулиа хэрэгжилтийг хангах уялдаа холбоог нь сайн харж, хэрэгжилтийг хангах асуудал маш чухал байгаа. Хэрэгжилт дээр хууль тогтоомж дээрээ байгаа боловчиг энийгээ яг практик дээрээ хэрэгжүүлдэггүй асуудал байна. Энийг бид нар холбогдох байгууллагуудтай, Хууль зүйн яамтайгаа ч, Тамгын газартайгаа ч ярьсан. Ер нь энэ тандан судалгаа, хэрэгжилтийн үнэлгээ 2-ыг яг юун дээр хийх юм гэдэг ялгаа, зааг 2023 онд Хууль тогтоомжийн хуульд орсон өөрчлөлтөөс болоод, ялгаа, зааг нь ойлгомжгүй болсноос болоод Засгийн газар ч зарим хууль тогтоогч нар ч хэрэгжилтийн үнэлгээ хийх ёстой юман дээрээ тандан судалгааг амарчилж хийгээд өгөөд байгаа дээр манай Тамгын газрынхан ийм байж болохгүй үнэлгээгээ хийдэг болгоё гэдэг санааг оруулж ирж байгаа юм.

Гэхдээ энэ өөрчлөлтийг оруулахын тулд бид нар илүү өргөн хүрээнд тэр 13.3 буюу тандан судалгааг тэгвэл яг ямар нөхцөлд хийх юм гэдгийг илүү тодорхой болгох шаардлагатай байгаа. Дараа дараагийн Хууль тогтоомжийн хуулийн жоохон тодорхой болгох шаардлагатай байгаа. Дараа дараагийн Хууль тогтоомжийн хуулийг жоохон нарийвчилж энэ үнэлгээгээ сайжруулъя. Заавал хэрэгжилтийн үнэлгээ хийж байж өргөн барьдаг болъё гэдэг агуулгыг хийхийн тулд энэнтэй холбогдож өөрчлөгдөх ёстой байгаа учраас энэ удаадаа энийгээ хасаад, дараа дараа энэ Хууль тогтоомжийн хууль дээр бас яг жоохон орхигдчихсон юмнууд байна лээ. Дахиад засчихмаар юмнууд бас харагдаж байна лээ.

Тэгэхээр энийг бас хамт хамтраад тэрийг нийлүүлж байгаад бас өөрчлөх юм бол энэ тандан судалгаа, хэрэгжилтийн үнэлгээ 2-ын ялгаа, заагийг гаргах байдлыг бас илүү сайн тодорхой болгох асуудал байгаа гэдгийг хэлье. Ер нь бол хууль тогтоомжид зарчмын шинж чанартай анхдагч найруулга биш бол хэрэгжилтийн үнэлгээ хийнэ гэдэг юмаа манай Засгийн газар ч гэсэн, хууль санаачлагчид ч гэсэн хатуу чанд баримтлах ёстой шүү. Уг нь хуулийн үзэл баримтлал нь, одоогийн хуулийн үзэл баримтлал нь ч гэсэн тийм байгаа гэдгийг энэ протоколд хэлж үлдээх гэсэн юм.

Х.Булгантуяа: Хууль зүйн байнгын хорооны саналтай холбоотойгоор Номинчимэг гишүүн дэмжиж үг хэллээ.

Саяын 5 дахь зарчмын зөрүүтэй санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 51.5 дахь хэсгийг хасах. Хууль зүйн байнгын хорооны санал. Санал хураалт.

66.3 хувиар дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.6.Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг үндэсний эрх зүйн тогтолцооны онцлог, хөгжлийн чиг хандлагыг харгалзан оновчтой хувилбарыг, үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан хийх.”. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

69.8 хувиар дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “38 дугаар зүйлийн” гэсний өмнө “34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэсний өмнө “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж” гэж,” гэж, 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн” гэсний өмнө “33.5 дахь хэсгийн “33.3.3-т” гэснийг “33.3.5-д” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө “38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийн “40.1.3-т” гэснийг “40.1.3, 40.1.4-т” гэж, 38.9 дэх хэсгийн “12.2.23, 12.2.24-т” гэснийг “12.4-т” гэж,” гэж, “40 дүгээр зүйлийн” гэсний өмнө “39.4 дэх хэсгийн “39.3-т” гэснийг “39.3, 39.4-т” гэж,” гэж, 5 дугаар зүйлийн “12.2.1,” гэсний дараа “12.2.17” гэж, мөн төсөлд “**6 дугаар зүйл**.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн зүйл нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.1 дэх заалтын “хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахад” гэснийг “хэрэгжүүлэхэд” гэж, 27¹.1.2 дахь заалтын “зорилтод” гэснийг “зорилт, үйлчлэх хүрээнд” гэж, 2 дугаар зүйлийн “жагсаасан” гэснийг “байрлуулсан” гэж өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дугаар дахь заалт буюу 27¹.1.5 дахь заалтын “үндсэн” гэснийг, 2 дугаар зүйлийн “39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийн “39.3” гэсний дараа “, 39.4” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “энэ хуулийн 41.3” гэсний дараа “, 41.4” гэж,” гэснийг, 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэснийг “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж хавсаргана” гэж,” гэснийг, “мөн зүйлийн 41.4, 41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10 дахь хэсгийн дугаарыг “41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10, 41.11” гэж, 41.5 дахь хэсгийн “41.4-д” гэснийг “41.5-д” гэж, 41.7 дахь хэсгийн “41.5-д” гэснийг “41.6-д” гэж,” гэснийг, мөн зүйлийн “эх бичвэрийн” гэсний өмнөх “англи хэл дээрх” гэснийг, 5 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг, ” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Хууль зүйн байнгын хороо санал гаргасан. Санал хураалт.

64.8 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

10.46 цаг

Гурав дахь асуудалдаа оръё. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны саналыг хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэг явуулсан бөгөөд хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгатай холбогдуулан ажлын хэсгээс асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу гүйцээн боловсруулж чиглэл өгсөн тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс 4 зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулж, мөн хуулийн төслийн 45-ын дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу ажлын хэсэг “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж Байнгын хороогоор хэлэлцүүлсэн бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг, хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ядамжавын Цэлмэн Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн, Максимын Чинбат Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Отгонбаярын Мөнхбаатар Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Лхагвын Данзанноров Монгол Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Пагмадоржийн Оростогоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга хурандаа, Сандагийн Тунгалагтамир Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга, Доржхүүгийн Сандаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны Нарийн бичгийн дарга Ариунтунгалаг бас ажлын хэсгийн гишүүнд гэж оруулж байгаа юм уу? Ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй байгаа гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

3 гишүүн байна. Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг асуулт асууж үг хэлнэ.

О.Номинчимэг: Энэ хууль дээр тэр 21.8 дахь хэсэг буюу хүний өмгөөлөгчөө авах эрхэд халдаж магадгүй заалт орсон байсан. Энийг ажлын хэсэг аваад бас өнөөдөр хураалгах санал дээр хасахаар орж ирсэн учраас асуултаа татаж авъя.

Х.Булгантуяа: Болчихсон. Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар? Байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин. Тэмүүжин гишүүн үгээ татлаа. Байнгын хороон дээр саналаа хэлчихсэн гээд .

Гишүүд асууд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд танхимдаа цуглаарай. Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа. Санал хураалтаа бэлтгэе. Гишүүд санал хураалтаа бэлдье.

Гишүүд санал хураалтад бэлдээрэй хуруугаа уншуулаад.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг явуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалтын 9 дэх хэсгийн “танилцуулж, төрийн нууцад хамаарахаас бусад хэсгийг” гэснийг “танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж,” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

58.4 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

65.2 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24/36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө.””. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

64 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 2 дахь хэсгийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг хасаж, мөн заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогчид хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хавтаст хэргийн материал танилцуулах хугацаа 7 хүртэл хоногт, бусад хэргийн материалтай ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах боломж, нөхцөлөөр хангана. Хавтаст хэргийн материал танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэл хоног байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан тус хугацааг мөрдөгч 14 хүртэл хонгоор сунгаж болно.”. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. Санал хураалтыг түр хүлээж байгаарай.

Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Манай ажлын хэсгээс бас энийг протоколд үлдээх ёстой гэж бас бид нар үзэж байгаа. Ер нь хавтаст хэрэгтээ бас мөрдөгч маш богино хугацаа өгөөд өмгөөлөгч нар бас энэнтэй бүрэн танилцах бололцоогүй буюу үйлчлүүлэгчийн эрх ашгаа хамгаалахад бас хүндрэлтэй байдлууд гардаг байсан.

Шүүх хуралдааны явц дахь мэтгэлцээнийг үр нөлөөтэй болгох үүднээс хавтаст хэрэгтэйгээ танилцах, тэн дээрээс бас холбогдох мэдээ, баримт материалыг хувилж авах асуудал бас чухал байгаа.

Тэгэхээр хялбаршуулсан журмаар хэргээ шийдүүлье гэсэн энэ асуудал дээр 7 хүртэл хоногоор байгаа. Бусад хэргүүд дээр буюу энэ дээр доод тал нь 3 хоногийн хугацаа өгөх ёстой шүү гээд 14 хоног хүртэл байж болно. Энэ хугацааг бас 14 хүртэл хоногоор хэргийн ээдрээ төвөгтэй байдлаар, холбоотойгоор сунгаж болно гэж орж байгаа. Энэ нь 1 удаагийн гэсэн бас хязгаарлалт байхгүй гэдэг зүйлийг би бас албан ёсны протоколд үлдээж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт.

57.3 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

10.58 цаг

Дөрөв дэх асуудалдаа оръё. Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жаргалан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхийд ганц Монгол наадам гэж Монголчууд бид ярьдаг. Монгол үндэстний бусдаас ондооших гол ялгарал, түүх, соёлын илэрхийллийн нэг бол үндэсний их баяр наадам билээ.

Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр билээ.

Монголчуудын үндэсний бахархаж бадрааж нүүдлийн соёл иргэншлийг дэлхий дахинаа сурталчилдаг үндэсний их баяр наадам нь монгол түмний үндэсний ижилсэл, ондоошлын ухамсарт гүн нөлөөтэй чухал үнэт зүйл арга хэмжээ юм.

Тиймээс Үндэсний их баяр наадам Монгол Улсын түүхийн бүхий л цаг хугацаанд Монголчуудын үндэсний ухамсрыг сэргээх, эв нэгдлийг хангах үйл хэрэгт онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Өнөөдөр Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний их баяр наадмын тухай хуулиар тусгайлан зохицуулж байна.

Үндэсний их баяр наадмын тухай хууль 2003 оны 6 дугаар сарын 19-нд батлагдсанаас хойш тус хуульд нийт 8 удаа өөрчлөлт оржээ. 2022 оны 6 дугаар сарын 28-нд шинэчилсэн найруулга хэлбэрээр хуульд томоохон өөрчлөлт орсон. Уг шинэчилсэн найруулгаар наадмын зохион байгуулалтын бүтэц, хариуцлагын тогтолцоо, уламжлалт спортын дүрэм, журам зэрэг гэх зэрэг наадмын зохион байгуулалт, үйл ажиллагааны зохицуулалтын шинж чанартай өөрчлөлтүүдийг хийжээ.

Харин Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, төрт ёсны түүхэн уламжлал, үндэсний эв нэгдлийн бэлгэдэл болохыг тодотгосон үзэл санааны өөрчлөлт хараахан хийгдээгүй байна.

Тиймээс 5 намын төлөөлөл бүхий 126 гишүүнтэй энэхүү парламент Үндэсний их баяр наадмын тухай хуульд үзэл санааны өөрчлөлт оруулах нь чухал гэж үзсэн болно.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.10-т Их Монгол Улс байгуулагдсаны ой болон Үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Ард ардын хувьсгалын ойн баяр наадмыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэнэ гэж заасан нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэн ач холбогдол бүхий тэмдэглэлт ойн баярыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх, олон нийтийн ухамсарт хоногшуулах нь зүйтэй гэж гэсэн санааг агуулжээ. Хэдий уг хуульд зөвхөн 2 түүхэн ойн баярыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх тухай заасан боловч үеийн Ерөнхийлөгч нарын нээлт, хаалтын үг болон Баяр наадмын тухай албаны мэдээлэлд Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баярын талаар олонтоо дурдаж цохон тэмдэглэсэн байдаг.

Тиймээс Монгол Улсын түүхэнд нэн чухал ач холбогдол бүхий Тулгар төр байгуулагдсаны ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойн баяр наадмыг Их Монгол Улс байгуулагдсаны ой, Ардын хувьсгалын ой, Улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд тусгайлан тусгах шаардлагатай гэж хууль санаачлагчид үзсэн.

Монгол Улсын төрт ёсны түүхэнд ач холбогдол бүхий дээрх ойн баяруудыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх талаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд тусгах санаачилгыг Улсын Их Хуралд суудалтай 5 намын төлөөлөл бүхий 40 гишүүн санаачилсан.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвөөс нэмэлт зардал гаргахгүй. Харин Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэн уламжлалыг бүрэн илэрхийлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг төлөвшүүлэх боломж бүрдэнэ гэж үзсэн.

Тиймээс энэхүү хуулийн төслийг хэлэлцэж, дэмжиж өгөхийг Улсын Их Хурлын гишүүд та бүхнээс хичээнгүйлэн хүсье.

Баярлалаа.

Х.Булгантуяа: Төслийн талаарх Төрийн байгуулалтын санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын төрт ёсны түүхэнд чухал ач холбогдол бүхий ойн баяруудыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх зохицуулалтыг Үндэсний их баяр наадмын тухай хуульд тусгаснаар Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэн уламжлалыг бүрэн илэрхийлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг төлөвшүүлж бэхжүүлэх, эв нэгдлийг хангах боломж бүрдэх чухал ач холбогдолтой гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 66.7 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалдаггүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна.

3 гишүүн нэрээ ирүүлсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар.

С.Зулпхар: Хуралдаан даргалагч болон Улсын Их Хурлын гишүүдийн бага үдийн мэндийг эрье.

Жаргалан нарын гишүүдийн санаачилсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг зарчмынх нь хувьд би бүрэн дэмжиж байгаа юм. Монголчууд бидний төрт улс, нийгэм соёлын аливаа түүхэн үйл явдал ямар ч эргэлзээгүй бидний хамтын үнэт зүйл байх ёстой. Үнэт зүйл байсаар байгаа. Нөгөөтэйгээр үндэстний нэгдмэл үнэт зүйлийн бас илэрхийлэл учраас энэнтэй уялдсан түүхэн цаг үеийг бид тэмдэглэх асуудал дээр бүгд нэгдмэл байр суурьтай байх ёстой гэсэн ийм ойлголттой байна.

Хуулийн төсөлд бол Тулгар төр байгуулагдсаны, Их Монгол Улс байгуулагдсаны, Үндэсний эрх чөлөөний хувьсгал болон Ардын хувьсгал, Ардчилсан хувьсгалын энэ түүхэн цаг үеийг нэгтгэсэн байдлаар жишээ нь баяр наадмын үеэр, Үндэсний их баяр наадмын үеэр бид тэмдэглэж байх ёстой юм байна гэсэн ийм санаа, санаачилга яваа юм байна. Энийг бол би онцгойлон сайшааж байна. Учир юу гэхлээр зэрэг бид түүхэндээ бас эзэн болж байх.

Тухайлбал, тулгар төртэй холбоотой энэ түүхэн он цагийг зарим улсын тэднийг буруутгаж байгаа юм биш зэвсэгт хүчний байгуулагдсаны түүхэн он цаг болгоод тэмдэглээд явж байдаг ийм жишээ нь нөхцөлүүд байгаа юм. Тэгэхлээр энэ бол Монголын газар нутаг дээр байгуулагдсан анхны жишээ нь тулгар төр, анхны жишээ нь төр улс учраас энэ түүхийг бол бид наадмын үеэр бол онцгойлон тэмдэглэх ёстой гэсэн байр суурьтай байна.

Нөгөөтэйгүүр Ардчилсан хувьсгал бол Монголчууд бидний хамтын бүтээл, хамтын хүсэл эрмэлзэл, хамтын үр дүн байсан учраас энийг бас бид түүхэн утгаар нь тэмдэглэх ёстой. Энийгээ бас энэ хуульчилж өгч байгаа нь их чухал байна гэж бодож байгаа юм. 2 асуулт байна Жаргалан гишүүнээс.

Би энэ танилцуулга уншсан тодорхой жишээ нь жилүүдэд энэ наадмын үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүд дээр саяын түүхэн он цагуудыг оруулсан байдлаар хэрэглэсэн байна. Тэгэхлээр та бүхэн хууль санаачлагч нар тэртээ тэргүй дефакто хэрэглэж байсан энэ хэллэг энэ түүхэн он цагийг Ди юүрий буюу хууль ёсны болгож байна гэж ойлгож байна. Энэ зөв үү гэж байгаа юм?

Хоёр дахь зүйл энэ мэдээж хэрэг түүхэн он цагтай холбоотой, түүхэн төр улстай холбоотой энэ түүхийн асуудал учраас түүхчдийн болон судлаачдын санал, дүгнэлтийг та бүхэнд бас нэмж оруулсан уу? Энэтэй холбоотой асуудлыг та бүхэн судалсан уу гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жаргалан асуултад хариулъя.

Б.Жаргалан: Энэхүү хуулийн төслийн үзэл санааг маш ойлгомжтойгоор тайлбарлаж дэмжсэн Зулпхар гишүүндээ баярлалаа. Үнэхээр Үндэсний их баяр наадам бол Монголчуудын үндэсний нэгдмэл үнэт зүйлийг илэрхийлсэн ийм баяр

байдаг. Үүгээрээ бид нар бас түүхэн цаг хугацаандаа онцгой үйл явдлууд байсныг хамтатган тэмдэглэх нь бас зүйтэй гэж харж байгаа.

Өнгөрсөн хугацаанд дээр дурдсан 5 ойн баярыг дефакто бас Монгол Улсын Ерөнхийлөгч нар дурдаж байсан. Тухайлах юм бол 2019 онд Үндэсний их баяр наадмыг тэмдэглэхэд албан ёсны эх сурвалжид Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 813, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 108, Ардын хувьсгалын 98, Ардчилсан хувьсгалын 30 жилийн ойн баяр гэсэн гэж цохон тэмдэглэж байсан бас тийм баримтууд бий.

Нөгөө талаас тулгар төртэй холбоотой 2010 онд Ерөнхийлөгчийн бас зарлиг гарсан байдаг. Тулгар төрийн ойн баярыг тэмдэглэе гэсэн агуулгаараа. Үүнд бас эрдэмтэн, судлаачдын дүгнэлтүүдийг хавсаргасан байдаг. Цаашлаад Ардчилсан хувьсгалын бас 20 жилийн ойг тэмдэглэх Ерөнхийлөгчийн зарлиг тухайн одон, медалийг олгох зарлигууд бас гарсан. Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойтой холбоотой 2011 онд бас Их Хурлын тогтоол батлагдаж, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ойн баярыг буюу 12 сарын 29-нийг үндэсний тэмдэглэлт өдөр болгож байгаа ийм бас хуулийн тогтоол гарсан байдаг гэх мэтчилэн яг эдгээр баяртай холбоотой хууль тогтоомжууд болон албаны эх сурвалжуудад тэмдэглэгдсэн зүйлүүд зөндөө байдаг. Эдгээртэй бас холбоотой эрдэмтэн, судлаачдын бас хэлэлцүүлгүүд, бүтээлүүд бас байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат.

Г.Очирбат: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Энэ хуулийг бас хамтарч санаачилсан хүний нэг байгаа. Парламентад суудалтай 5 намын Их Хурлын гишүүд нэг дуу хоолойтойгоо дэмжиж байгаа. Энэ цаг хугацааны хувьд зайлшгүй хийгдэх ёстой, орж ирэх ёстой хуулийн төсөл гэж харж байгаа. Үндэсний их баяр наадам гэдэг Монгол Улсын эв нэгдэл, Монголын 1 сая 506м2 талбайд оршин сууж байгаа 3.5 сая хүн болгоны зүрх сэтгэл байдаг өв уламжлал, түүх бүх л юм энэ Үндэсний их баяр наадам руу харуулдаг. Яг энэнтэй холбоотойгоор 1989, 1990 оны тэр Ардчилсан хувьсгалын, өнөөдрийн ялангуяа энэ залуучуудын эрх, эрх чөлөөнийхөө төлөө дуу хоолойгоо хүргэх энэ суурь болсон энэ түүхэн он жилийг бас энэ Баяр наадмын тухай хууль дээрээ нэмж оруулж ирэх нь зайлшгүй цаг хугацааны асуудал болоод орж ирж байгаа.

Асуулт асууна гэхээсээ илүүтэйгээр Улсын Их Хурлынхаа эрхэм 126 их хурлын гишүүдэд та хэдээсээ бас нэг талдаа энэ үндэсний энэ үзэл санаа, нэгдмэл байдлаа хамгаалаад энэ хуулийн төслийг бас дэмжиж өгөөсэй гэж хүсэх гэсэн юм. Мэдээж хүн болгон дотроо янз бүрийн бодолтой, үзэл баримтлалаараа бид нар хуваагддаг ч Үндэсний их баяр наадам энэ дээрээ эв нэгдэлтэй байх ёстой, улс эх орныхоо эрх ашгийг нэгт тавих ёстой. Парламентад суудалтай 126 Их Хурлын гишүүд та бүхэн маань хэлэлцэхийг нь дэмжиж өгөөрэй гэж хүсэх гэсэн юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Очирбат гишүүн үг хэллээ. Асуулт асуусангүй тээ Очирбат гишүүн? Үг хэллээ.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

Улсын Их Хурлын гишүүн 2 гишүүн нэрээ ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Номин. Индрээс үг хэлнэ шүү. 1 номерын индрээс Чинбатын Номин гишүүн.

Ч.Номин: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэхүү хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Монгол Ардын намын хувьд ч гэсэн социал демократ үзэл баримтлалтай. Энэний үнэ цэн ардчилал байдаг. Энэ утгаараа бол бид бүхэн энэ хуулийг бүрэн хэмжээнд дэмжиж байгаа.

Практик шаардлагын хувьд бол бас энэ шаардлагатай байдаг. Жилийн жилд яг энэхүү арга хэмжээг Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд хэрхэн Үндэсний их баяр наадмаа тэмдэглэн өнгөрүүлэх вэ, тулгар төр байгуулагдсаны, цаашлаад Их Монгол Улс байгуулагдсан гээд янз янзаар хэлэгддэг. Энэ утгаараа бол энэхүү нэршлийг хуульчилж цаашдаа бас практикт хэрэглэхэд амар болгох нь зүйтэй гэж үзэж байгаа.

Ер нь нөгөө талдаа Үндэсний их баяр наадмын тухай хуулийг бид бүхэн бас харж үзэх шаардлагатай байгаа гэж үзэж байгаа. Яагаад вэ гэхээр энэхүү Баяр наадмын тухай хууль бол нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх ард иргэдийн баяр наадмаа тэмдэглэн өнгөрүүлэх хэм хэмжээг тодорхойлох хууль байхад үүн дотор үндэсний спортын асуудлууд бас орж ирдэг. Ингэснээр бас баяр наадам дээр ард иргэдэд бухимдал үүсгэх нөхцөлүүд гарч ирдэг. Энэ ч утгаараа энэ дотроос энэ үндэсний спортыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар салгаж цаашдаа авч үзэх нь чухал гэж үзэж байгаа.

Яагаад вэ гэхээр үндэсний спорт бид бүхний хувьд өв соёл байдаг. Энэ ч утгаараа мэргэжлийн спорт, цаашлаад өндөр дээд хэмжээний спортоос ялгавартай ялгаварлаж өөр байдлаар зохицуулах, хуулийн зохицуулалт хийх нь шаардлагатай бөгөөд үүнийг Үндэсний баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх буюу ард иргэдийн баяр наадмаа хэрхэн тэмдэглэн өнгөрүүлэхээс салгаж үзэх нь зүйтэй гэж үзэж байгаа учраас цаашид энэ Үндэсний их баяр наадмын тухай хууль дээр өөрчлөлт, нэмэлтээр оруулах нь зүйтэй гэж үзэж байгаа. Энэхүү баяр наадмыг талаар тэмдэглэлт хүрээнд хэрхэн дурдаж, хэрхэн нэршиж явах вэ гэдэг энэ хуулийг бүрэн дэмжиж байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Номин гишүүн дэмжиж үг хэллээ.

Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Одоо Байнгын хорооны саналаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Одбаяр гялзаарай.

Санал хураалт.

Санал 64.4 хувиар дэмжигдлээ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулъя.

Үдээс хойших үдээс хойших хуралдаан 14 цагаас үргэлжилнэ. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай, мөн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох асуудлуудыг хэлэлцэнэ.

11.16 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

